

# SikaGrout®214

## Өөрөө тэгширдэг, агшдаггүй цементэн хольц

### Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaGrout® 214 нь орчны температурын хэлбэлзэлд ажиллах чадвартай өөрөө тэгширдэг, агшдаггүй, өндөр үзүүлэлттэй, цементэн хольц юм.

### Хэрэглээ:

- Тоног төхөөрөмжийн сууринд
- Угсармал барилгын баганад
- Бетон анкорт
- Гүүрийн хольхивчинд
- Хөндий зай завсар бөглөхөд
- Бөглөх шаардлагатай боловч гүйцэтгэл хийхэд төвөгтэй бүх төрлийн хөндий, зай завсаруудад

### Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

SikaGrout® 214 нь хэрэглэхэд хялбар савлагдсан бэлэн хольц бөгөөд (зөвхөн ус нэмж хийнэ) доорх давуу талтай:

- БНХАУ-д GB стандартад нийцсэн – GB/T50448-2008 (2-р төрөл), JC/T 986-2005 YB/T 9261-98 (2-р төрөл)
- Хольж зуурах болон хэрэглэхэд хялбар
- Урсах чадвар маш сайн
- Агшдаггүй
- Бат бэхийг огцом өсөлт
- Эцсийн бат бэхийн өндөр үзүүлэлтүүд
- Цохилтын хүч болон доргилтод тэсвэртэй
- Хоргүй, зэвэрдэггүй
- Төмөр болон хлор агуулаагүй

### Техникийн үзүүлэлт

#### Өнгө / төлөв

Саарал өнгийн нунтаг

#### Нунтаг материалын нягт

~ 1,5 кг/л

#### Шингэн зуурмагын нягт

2.13 – 2.20 кг/л

#### Хадгалах хугацаа

Сав баглаа боодлыг онгойлгож, гэмтээлгүйгээр, хуурай сэрүүн орчинд 9 сар хадгална.

#### Савлагаа

25 кг цаасан ууттай

## Үзүүлэлт

Доорх үзүүлэлтүүд нь 25 кг нунтаг бүтээгдэхүүнийг 3.75 литр устай хольж зуурсан зуурмагт суурилсан болно:

Урсалт/гархалт (GB/T 50448-2008): цементэн гроутын хэрэглээний техникийн код: эхэн үеийнх  $\geq 340$  мм, 30 минутын дараах:  $\geq 310$  мм

Шахалтын бат бэх (JC/T 986-2005)

Бэхжилтийн хугацаа	1 хоног	3 хоног	7 хоног	28 хоног
Шахалтын бат бэх (Mpa)	$\geq 25$	$\geq 40$	$\geq 50$	$\geq 70$

## Хэрэглэх заавар

### Гадаргууг бэлдэх

Бетоны гадаргуу бат бэх байж, хуурай, тос тосоол, бетон арчилгааны бодисууд, будаг түрхлэгүүд болон бусад бохирдол болон сул хэсгүүдээс бүрэн ангид байх хэрэгтэй.

Метал гадаргуу (төмөр, ган) нь тос тосоол, зэврэлт, шохойжилт зэргээс ангид цэвэр байх шаардлагатай.

Шингээгч гадаргууд зуурмагыг цутгахаас өмнө сайтар чийглэх хэрэгтэй. Гэхдээ илүүдэл тогтсон ус гадаргуу дээр үлдэх ёсгүй.

### Холих

Нэгж савлагаатай бүтээгдэхүүнийг (25 кг нунтаг) ойролцоогоор 3.6~3.9 л устай холихыг зөвлөж байна.

Зуурмагт орох усны 70-80%-ийг агуулсан усыг тохиромжит саванд хийж, дээрээс нь нунтаг SikaGrout® 214 бүхий хольцыг бага багаар нэмж хийж сайтар хольж өгнө. Дараа нь үлдэгдэл усыг нэмж хийгээд нэгэн жигд зуурмаг болтол 2-3 минутын турш бага хурдтай цахилгаан холигчоор хольно (хамгийн ихдээ мин-д 800 эргэлттэй). Шингэн зуурмагаа саванд нь ойролцоогоор 1-2 минут амараагаад дахин 1-2 минутын турш хольсоны дараа хэрэглэхэд бэлэн зуурмаг болно.

### Хэрэглээ

Шингэн зуурмагаа нэн даруй цутгах шаардалагай бөгөөд зуурмагт агуулагдах агаар чөлөөтэй гарах боломжоор хангагдсан байх ёстой.

Суурийн хавтанд цутгалт хийх тохиолдолд зуурмагын урсгалыг таслахгүйгээр цутгалтыг хийх үүднээс даралтад насосны толгойг урьдчилан тохируулаарай.

Зуурмагын ил байх талбай бага байх тусам илүү үр дүнтэй байна.

Талбай ихтэй эсвэл зузаан цутгалтын үед шингэн зуурмагт хагаралгүй бат бөх дүүргэгчийг нэмж өгсөнөөр бэхжилтийн үеийн температурын өсөлтийг бууруулж өгдөг. Гэвч дүүргэгчийн хэмжээ нь SikaGrout® 214 – ийн хэмжээнээс илүүгүй байх шаардлагатай.

Шаардлагатай тохиолдолд манай Техникийн ажилчдаас зөвлөгөө авна уу.

### Гүйцэтгэлийн температур

Хамгийн багадаа +5°C, хамгийн ихдээ +35°C

### Арчилгаа

Зуурмагын гадаргуунд Antisol E түрхэх буюу бусад арчилгааны аргачлалыг хэрэглэнэ.

### Цэвэрлэгээ

Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ хатахаас нь өмнө халуун бүлээн усаар цэвэрлэнэ. Хатаж бэхэжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

**Чухал санамж**

SikaGrout® 214 –ийг зөвхөн гроутын зориулалтаар ашиглана. Хэт бага хөндий зай завсарын өргөн нь 10 мм байна.

**Зарцуулалт**

SikaGrout® 214	1.88 кг	25 кг	75.5 x 25 кг
Ус	0.283 л	3.75 л	283 л
Зуурмагын эзлэхүүн	1 л	13.25 л	1 м³

**Хэрэглээний нэмэлт мэдээлэл****Суурь хавтангийн****Зуурмаг**

Гадаргуйг урьдчилан норгож өгнө. Зуурмагын тогтмол урсалтыг хангах зорилгоор цутгалтыг тогтмол даралттайгаар гүйцэтгэх шаардлагатай.

Зуурмаг нь суурьны гадаргуун нүх сүвийг бүрэн дүүргэж тэгширсэн эсэх болон зуурмагт агуулагдах агаарын бөмбөлөгүүдийг гаргахын зорилгоор гинж болон төмөр утас ашигла сайтар хутгаж өгөөрэй.

**Машин тоног төхөөрөмжийн****зуурмаг**

Гадаргууг урьдчилан норгож өгнө, боолтны нүхэнд тогтсон ус үлдээж болохгүй. Боломжтой бол эхлээд анкороын боолтуудаа гроут бүхий зуурмагаар дүүргээд, дараа нь дэр бүхий зуурмагын цутгалтыг хий. Зуурмагыг нэгэн жигд урсгаж өгөх хэрэгтэй. Анкороын боолтоос гадаргуу хүртэлх зай нь хамгийн багадаа 3 х зуурмагын дүүргэгчийн хамгийн том диаметр (ойролцоогоор 10мм) байна.

**Их хэмжээтэй зуурмаг**

Цутгалтын хэмжээнээс хамаараад зуурмагт 4~8 мм, 8~16 мм, 16~32 мм-ийн дүүргэгчийг хийх боломжтой. Дүүргэгчийн хэмжээ нь зуурмагын жингийн 50%~100% хүртэл орох боломжтой. Буталсан чулуунаас илүүтэйгээр мөлгөр чулууг хэрэглэх нь зохимжтой. Цутгалтын нягтралыг сайжруулах зорилгоор шингэн зуурмагыг доргиулж өгөх боломжтой.

**Дүгнэлт**

Энэхүү Техникийн зааварчилгаанд лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.

**Дотоодын хязгаарлалт**

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

**Эрүүл мэнд, Аюулгүй  
Ажиллагааны мэдээлэл**

Бүтээгдэхүүнийг зөв хэрэглэх, хадгалах, химийн бодисын хаягдлыг зайлуулах зэрэг Аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мөн физик, экологи, хортой байдал болон бусад аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг цогцоор агуулсан Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас авах бүрэн боломжтой.

**Хууль эрх зүйн мэдээлэл**

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн

# Construction

үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

---

Sika (China) Ltd.  
No 28, Jingdong Rd,  
Suzhou Industrial Park,  
Suzhou, Jiangsu, P.R. China  
Post Code: 215121  
Tel: (86) 512 6273 2888  
Fax: (86) 512 6287 7070  
Email: [marketing@cn.sika.com](mailto:marketing@cn.sika.com)

